



ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН  
ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2020 оны 07 сарын 02 өдөр

Дугаар А/150


Улаанбаатар хот

Журам батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.1, 8.4-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Хяналт шалгалтын үйл ажиллагаанд зөөврийн төхөөрөмжийг ашиглах журам”-ыг хавсралтаар баталсугай.
2. Энэ тушаалаар баталсан журмыг хэрэгжүүлж ажиллахыг холбогдох нэгжүүдэд, тушаалын хэрэгжилтэд хяналт тавихыг Захиргаа, удирдлагын газар /Д.Давааням/-т тус тус даалгасугай.


ДАРГА



Д.МӨРӨН

000009818

Гадаадын иргэн, харьяатын газрын  
даргын 2020 оны 07 сарын 02 өдрийн  
4/100 дугаар тушаалын хавсралт



## ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ЗӨӨВРИЙН ТӨХӨӨРӨМЖИЙГ АШИГЛАХ ЖУРАМ

### Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Гадаадын иргэнд тавих шуурхай хяналт шалгалтын үйл ажиллагаанд зөөврийн хяналт шалгалтын төхөөрөмжийг /цаашид “зөөврийн төхөөрөмж” гэх/ ашиглахад энэхүү журмыг баримтална.

### Хоёр. Зөөврийн төхөөрөмжийг ашиглах

2.1. Гадаадын иргэний хяналтын улсын ахлах байцаагч, байцаагч /цаашид “байцаагч” гэх/ нь хяналт шалгалт зохион байгуулагдахаас ажлын 1 хоногийн өмнө хяналт шалгалтад хамаарах гадаадын иргэдийн мэдээллийг зөөврийн төхөөрөмжид байршуулах зорилгоор хяналт шалгалтын асуудал хариуцсан нэгжийн даргын зөвшөөрлийг мэдээллийн технологийн асуудал хариуцсан нэгжид хүргүүлнэ.

2.2. Энэ журмын 2.1-д заасан зөвшөөрлийг үндэслэн мэдээллийн технологийн асуудал хариуцсан нэгж нь зөөврийн төхөөрөмжид суулгах мэдээллийг хяналт шалгалтын өмнө бэлэн болгоно.

2.3. Зөөврийн төхөөрөмжийг хүлээн авах, хүлээлгэн өгөхдөө тэмдэглэл хөтөлж, гарын үсэг зурна.

2.4. Байцаагч нь зөөврийн төхөөрөмжийг ашиглах явцад гарсан эвдрэл, гэмтэл, алдаа болон санал хүсэлтийн талаар мэдээллийн технологийн асуудал хариуцсан нэгжид мэдэгдэнэ.

### Гурав. Зөөврийн төхөөрөмжийн аюулгүй байдал, хориглох зүйл

3.1. Мэдээллийн технологийн асуудал хариуцсан нэгж нь хяналт шалгалт зохион байгуулагдах тухай бүрт зөөврийн төхөөрөмжид нэвтрэх эрх, нууц үгийг үүсгэх бөгөөд үүсгэсэн нууц үг, мэдээллийн баазыг хуулбарлан авч хадгалж байна.

3.2. Зөөврийн төхөөрөмжид үүсгэсэн мэдээллийн сан /өгөгдлийн бааз/-г тусгай код (шифр)-оор нууцалсан байна.

3.3. Мэдээллийн сан бүхий зөөврийн төхөөрөмж алдагдах тохиолдолд нууц үгийг 3 удаа буруу оруулахад сан устдаг байхаар техникийн тохиргоог хийсэн байна.

3.4. Зөөврийн төхөөрөмжийг хэрэглэгчид дараахь зүйлийг хориглоно:

3.4.1. Зөөврийн төхөөрөмж дэх өгөгдлийн баазыг хуулбарлах;

3.4.2. Зөөврийн төхөөрөмжийг бусад компьютер, техник хэрэгсэл, интернет сүлжээнд холбох;

3.4.3. Бусдад дамжуулан ашиглуулах;

3.4.4. Зөөврийн төхөөрөмжид нэмэлтээр програм хангамж суулгах.

3.5. Зөөврийн төхөөрөмжийг эвдсэн, гэмтээсэн, алдсан албан хаагчид эд хөрөнгийн хариуцлага ногдуулна.

3.6. Энэ журмын 3.4-т заасныг зөрчсөн албан хаагчид Төрийн албаны тухай хууль болон Хөдөлмөрийн дотоод журамд заасан хариуцлага ногдуулна.

-oOo-